



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2018. оны 02. сарын 05.-ны
өдрийн 3849 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 01 сарын 17 өдөр

Дугаар A/09

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн зурагт болон бичмэл
анхааруулгыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг үндэслэн Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.5 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Тамхины хайрцаг, сав, баглаа боодол дээр хэвлэх, тамхины хэрэглээнээс хүний эрүүл мэндэд учрах хор хөнөөлийг харуулсан эрүүл мэндийн зурагт болон бичмэл анхааруулгын шинэчилсэн загварыг нэгдүгээр, тэдгээрт тавигдах шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн зурагт болон бичмэл анхааруулгыг тамхин бүтээгдэхүүний техникийн ерөнхий шаардлагад тусгах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/-т, хүн амд тамхинаас үүдэлтэй хор хөнөөлийг сар бүр тодорхой сэдвийн дор тогтмол сурталчилах тогтолцоо бүрдүүлж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Б.Цогтбаатар/, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв /Л.Насанцэнгэл/-д тус тус даалгасугай.

3. Эрүүл мэндийн анхааруулга болон тамхи татахыг хориглосон анхааруулга, тамхины хор хөнөөлтэй тэмцэх, сурталчилах арга хэмжээний зардлыг Эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлж байхыг Бодлого, төлөвлөлтийн газар /Р.Оюунханд/-т, уг тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 36 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД


Бүртгэлийн дугаар 09

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ


ХУУЛБАР ҮНЭН

Хуулоар олгосон ажилтны гарын үсэг

2018 оны 01 сарын 18-ний өдөр



Д.САРАНГЭРЭЛ




Эрүүл мэндийн сайдын 2018 оны
01 дугаар сарын 17-ний 19-рөдрийн
4/09 тоот тушаалын нэгдүгээр
хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗУРАГТ БОЛОН БИЧМЭЛ АНХААРУУЛГЫН
ШИНЭЧИЛСЭН ЗАГВАР

Эрүүл мэндийн зурагт болон бичмэл анхааруулга №1



Эрүүл мэндийн зурагт болон бичмэл анхааруулга №2



Эрүүл мэндийн зурагт болон бичмэл анхааруулга № 3



ТАМХИ БЭЛГИЙН
СУЛРАЛД ХҮРГЭНЭ

Эрүүл мэндийн зурагт болон бичмэл анхааруулга №4



ХҮҮХЭД ДАМ
ТАМХИДАЛТЫН
ЗОЛИОС БОЛДОГ.



Эрүүл мэндийн зурагт болон бичмэл анхааруулга №5

Тамхинд хорт хавдар
үүсгэгч 60 химиин
хортой бодис байдаг.



Эрүүл мэндийн зурагт болон бичмэл анхааруулга № 6

ТАМХИ НЬ УРАГ ЗУЛБАХ
ШАЛТГААН БОЛДОГ



Эрүүл мэндийн сайдын 2018.
оны 01 дүгээр сарын 17-ний
өдрийн А/09 дүгээр тушаалын
хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗУРАГТ БОЛОН БИЧМЭЛ АНХААРУУЛГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Тамхин бүтээгдэхүүний хайрцаг, сав, баглаа боодол дээр энэхүү тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн зурагт болон бичмэл анхааруулга” батлагдсан байдлаараа хэвлэгдсэн байна.

2. Тус тушаалаар батлагдсан эрүүл мэндийн зурагт болон бичмэл анхааруулгыг хооронд нь сольж байрлуулахгүй.

3. Эрүүл мэндийн бичмэл анхааруулгын хэсэг нь эрүүл мэндийн зурагт анхааруулгын эзлэх талбайн хэмжээнд багтаахгүйгээр тусдаа байрлана.

4. Эрүүл мэндийн зурагт болон бичмэл анхааруулгын талбайд ямар нэгэн нэмэлт зураг, бичиглэл хийхгүй.

5. Эрүүл мэндийн зурагт анхааруулгад тавигдах шаардлага:

5.1. Тамхинаас хүний эрүүл мэндэд учруулах хор хөнөөлийг харуулсан эрүүл мэндийн зурагт анхааруулгад зурган зурган төрөлтэй байна.

5.2. Янжуур тамхины хайрцагны нүүр болон ар талын талбайн хэсгийн дунд хэсгийн 65 хувийг эрүүл мэндийн зурагт анхааруулга эзэлсэн байна.

5.3. Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины сав, баглаа боодлын нүүрэн талын гадаргууны талбайн дунд хэсгийн 65 хувийг эрүүл мэндийн зурагт анхааруулга эзэлсэн байна.

5.4. Зурагт анхааруулга нь эх хувьтайгаа адилхан өнгөтэй, тусгал сайтай, тод харагдахуйц, 300 dpi нягтралтай, 600*800 пиксел хэмжээтэй, JPEG файл байна

5.5. Зурагт анхааруулгын хүрээ нь нэг мм өргөнтэй хар өнгийн хүрээтэй, талбайн суурь өнгө цагаан байна.

6. Эрүүл мэндийн бичмэл анхааруулгад тавигдах шаардлага:

6.1. Эрүүл мэндийн бичмэл анхааруулга 6 төрөлтэй байна.

6.1.1. Тамхи хорт хавдар үүсгэнэ.

6.1.2. Тамхи үхжил үүсгэнэ.

6.1.3. Тамхи бэлгийн сурталд хүргэнэ.

6.1.4. Хүүхэд дам тамхидалтын золиос болдог.

6.1.5. Тамхинд хорт хавдар үүсгэгч 60 химийн хортой бодис байдаг.

6.1.6. Тамхи нь ураг зулбах шалтгаан болдог.

6.2. Янжуур тамхины эрүүл мэндийн бичмэл анхааруулгад тавигдах шаардлага:

6.2.1. Эрүүл мэндийн бичмэл анхааруулга нь эрүүл мэндийн зурагт анхааруулгын дээд хэсэгт буюу тагны онгойх хэсэг дээр байрлана.

6.2.2. Эрүүл мэндийн бичмэл анхааруулгын талбайн хэмжээ уртаараа 5 см, өргөнөөрөө 2 см буюу 10 см.квадратаас доошгүй талбайг эзэлсэн байна.

6.2.3. Эрүүл мэндийн бичмэл анхааруулгын эзлэх талбайн суурь өнгө хар, хүрээ нь 3мм улаан өнгөтөй, бичиглэл нь цагаан өнгөтэй, тодор бичигдсэн байна.

6.2.4. Эрүүл мэндийн бичмэл анхааруулгын бичиглэл компьютерийн "Arial"-фондын "12" хэмжээтэй, "bold", том үсгийн хэмжээгээр бичигдсэн байна.

6.3. Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины сав, баглаа боодол дээрх эрүүл мэндийн бичмэл анхааруулгад тавигдах шаардлага:

6.3.1. бичмэл анхааруулга нь эрүүл мэндийн зурагт анхааруулгын дээд хэсэгт байрлана.

6.3.2. бичмэл анхааруулгын талбайн хэмжээ уртаараа 5 см, өргөнөөрөө 2 см буюу 10 см.квадратаас доошгүй талбайг эзэлсэн байна.

6.3.3. бичмэл анхааруулгын эзлэх талбайн~~1~~ суурь өнгө хар, хүрээ нь 3мм улаан өнгөтөй, бичиглэл нь цагаан өнгөтэй, тодор бичигдсэн байна.

6.3.4. Эрүүл мэндийн бичмэл анхааруулгын~~143~~ бичиглэл компьютерийн "Arial"-фондын "12" хэмжээтэй, "bold", том үсгийн хэмжээгээр бичигдсэн байна.

-оОо-